

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит.
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3.Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	18
3.7. Шилэн дансны мэдээлэл	20
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.9. Аудитын илрүүлэлт.....	20
Залруулсан алдаа.....	20
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	21
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	22
4. Менежментийн захидал.....	23
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26
6.Албан шаардлага.....	28



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.02.25 № 07/516
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам тайлант онд дэвшүүлсэн 65 зорилтын хүрээнд 190 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 92.4 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	703,356,400.59	1,012,075,530.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	900.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	900.00	0.00
31210	Төгрөг	900.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	900.00	0.00
33	АВЛАГА	218,072,045.82	174,311,072.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	198,272,045.82	167,765,030.00
33500	Бусад авлага	19,800,000.00	6,546,042.00
33510	Байгууллагаас авах авлага	19,800,000.00	6,546,042.00
34	УРЬДЧИЛГАА	160,647,070.00	88,627,625.00
34600	Урьдчилж гарсан зардал	160,647,070.00	88,627,625.00
35	БАРАА МАТЕРИАЛ	104,636,384.77	211,957,533.15
35400	Хангамжийн материал	104,636,384.77	211,957,533.15
35410	Бичиг хэргийн материал	57,783,120.00	58,516,329.09
35420	Аж ахуйн материал	32,642,378.47	36,813,105.74
35430	Сэлбэг хэрэгсэл	300,000.00	694,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,272,400.00	1,086,587.80
35470	Бусад хангамжийн материал	12,638,486.30	114,847,510.52
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	220,000,000.00	537,179,300.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	220,000,000.00	537,179,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,796,692,357.38	7,275,314,936.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,796,692,357.38	7,275,314,936.97
39200	Биет хөрөнгө	5,049,983,456.00	5,219,936,175.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,728,716,115.00	3,728,716,115.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-93,217,902.84	-186,435,805.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	264,698,000.00	467,146,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-142,685,788.47	-263,912,762.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,906,989,469.08	2,495,933,768.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-934,205,719.51	-1,363,172,910.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	547,845,876.80	642,105,439.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-302,043,768.06	-374,331,143.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	73,143,374.00	73,143,374.00
39217	Ном	743,800.00	743,800.00
39300	Биет бус хөрөнгө	1,746,708,901.38	2,055,378,761.08
39301	Програм хангамж	2,198,613,661.00	2,207,175,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-483,727,823.62	-879,986,866.90
39303	Бусад биет бус хөрөнгө	34,096,140.00	769,507,340.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,273,076.00	-41,316,712.02
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,500,048,757.97	8,287,390,467.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,745,877.91	4,021,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,745,877.91	4,021,400.00
41300	Өглөг	10,745,877.91	4,021,400.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,225,258.35	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	435,419.56	0.00

41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,085,200.00	1,251,400.00
41360	Бусад өглөг	0.00	2,770,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	2,770,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,489,302,880.06	8,283,369,067.12
51	Засгийн газрын хувь оролцоо	7,489,302,880.06	8,283,369,067.12
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	34,096,140.00	769,507,340.00
51200	Хуримтлагдсан үр дүн	7,008,137,342.10	7,066,792,329.16
51210	Өмнөх үеийн үр дүн	7,367,120,582.30	6,879,484,844.10
51220	Тайлант үеийн үр дүн	-358,983,240.20	187,307,485.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	447,069,397.96	447,069,397.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,500,048,757.97	8,287,390,467.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөг)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	91,828,840,238.31	94,346,627,046.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,483,500.00	1,339,439,693.48
120	Нийтлэг татварын бус орлого	102,483,500.00	1,339,439,693.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	83,500.00	154,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	83,500.00	154,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	102,400,000.00	704,356,019.08
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	634,929,674.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	91,726,356,738.31	93,007,187,353.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	88,825,829,900.00	91,242,023,668.45
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	88,825,829,900.00	91,242,023,668.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,900,526,838.31	1,765,163,685.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,776,832,444.31	1,680,809,685.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	956,903,294.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	154,343,400.00	74,354,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,447,700.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	92,188,325,703.39	93,939,319,561.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,188,325,703.39	93,939,319,561.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,045,728,600.51	7,393,241,696.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,046,173,889.00	2,879,081,498.03
210101	Үндсэн цалин	2,044,328,875.00	2,879,081,498.03
210102	Нэмэгдэл	1,845,014.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	262,747,762.86	375,634,608.69
210201	Тэтгэврийн даатгал	180,158,075.06	317,773,647.87
210202	Тэтгэмжийн даатгал	21,175,421.95	14,832,075.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,377,137.56	19,191,606.25
210204	Ажилгүйдлийн даатгал	4,094,284.39	2,866,314.99
210205	Эрүүл мэндийн даатгал	40,942,843.90	20,970,964.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,950,845.00	185,794,400.00
210301	Гэрэл, цахилгаан	82,183,900.00	85,200,000.00
210302	Түлш, халаалт	74,794,400.00	74,794,400.00
210303	Цэвэр, бохир ус	24,646,600.00	25,800,000.00
210304	Байрны түрээс	35,325,945.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	249,412,967.76	237,862,596.41
210401	Бичиг хэрэг	159,476,281.76	129,983,650.00
210402	Тээвэр, шатахуун	19,381,000.00	18,394,290.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,785,611.00	40,283,447.39

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,415,075.00	49,201,209.02
210408	Бараа материал акталсны зардал	6,355,000.00	0.00
2105	Нормативт зардал	163,271,716.59	55,160,700.00
210502	Хоол, хүнс	163,271,716.59	55,160,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	138,377,711.00	102,946,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,317,711.00	100,050,000.00
210604	Урсгал засвар	8,060,000.00	2,896,200.00
2107	Томилолт, зочны зардал	279,113,450.00	55,522,785.00
210701	Гадаад албан томилолт	36,793,282.00	0.00
210702	Дотоод албан томилолт	242,320,168.00	55,522,785.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,015,483,857.52	1,120,250,652.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,005,116,509.52	1,108,088,031.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,648,014.00	8,345,595.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,300.00	631,126.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,500,000.00	2,137,500.00
210807	Газрын төлбөр	868,034.00	993,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,674,196,400.78	2,380,988,256.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,575,638,627.14	1,295,211,413.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,334,120.00	96,461,602.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	978,223,653.64	989,315,241.49
212	ТАТААС	497,038,200.00	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	0.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,645,558,902.88	86,546,077,865.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	83,631,731,201.49	85,922,132,955.28
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	83,631,731,201.49	85,731,682,559.28
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	190,450,396.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,474,800.00	144,205,021.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	120,014,421.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,474,800.00	24,190,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,352,901.39	479,739,888.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,282,359.55	479,719,931.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	70,541.84	19,957.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-359,485,465.08	407,307,485.06
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	502,224.88	0.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	502,224.88	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	220,000,000.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	0.00	220,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-358,983,240.20	187,307,485.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөг)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	91,798,805,165.16	93,076,960,901.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,029,800.00	154,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,029,800.00	154,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,029,800.00	154,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,029,800.00	154,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	91,796,775,365.16	93,076,806,901.27
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	88,825,829,900.00	91,242,023,668.45
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	88,825,829,900.00	91,242,023,668.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,970,945,465.16	1,834,783,232.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,847,251,071.16	1,750,429,232.82
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	956,903,294.00	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	154,343,400.00	74,354,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,447,700.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,788,007,265.16	93,048,791,199.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	91,788,007,265.16	93,048,791,199.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,447,138,116.46	6,351,957,062.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,873,752,700.00	2,748,922,563.23
210101	Үндсэн цалин	1,263,286,400.00	1,947,560,576.31
210102	Нэмэгдэл	468,896,300.00	619,022,602.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	141,570,000.00	182,339,384.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	234,219,100.00	349,927,050.88
210201	Тэтгэврийн даатгал	162,468,900.00	238,521,074.66
210202	Тэтгэмжийн даатгал	17,937,600.00	27,851,744.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,350,000.00	22,281,555.21
210204	Ажилгүйдлийн даатгал	3,587,500.00	5,570,188.71
210205	Эрүүл мэндийн даатгал	35,875,100.00	55,702,488.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,950,845.00	185,794,400.00
210301	Гэрэл, цахилгаан	82,183,900.00	85,200,000.00
210302	Түлш, халаалт	74,794,400.00	74,794,400.00
210303	Цэвэр, бохир ус	24,646,600.00	25,800,000.00
210304	Байрны түрээс	35,325,945.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	241,130,128.20	201,186,809.95
210401	Бичиг хэрэг	176,876,761.76	98,003,550.00
210402	Тээвэр, шатахуун	17,120,000.00	17,962,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,350,191.44	40,718,866.95
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,783,175.00	44,502,093.00
2105	Нормативт зардал	163,271,716.59	55,160,700.00
210502	Хоол, хүнс	163,271,716.59	55,160,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	138,436,711.00	125,673,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	130,317,711.00	100,219,000.00
210602	Тавилга	0.00	7,600,000.00
210604	Урсгал засвар	8,119,000.00	17,854,400.00
2107	Томилолт, зочны зардал	281,504,450.00	55,522,785.00
210701	Гадаад албан томилолт	21,554,233.00	0.00
210702	Дотоод албан томилолт	259,950,217.00	55,522,785.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,240,440,318.52	1,276,535,337.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,221,483,650.52	1,272,085,161.96
210803	Даатгалын үйлчилгээ	9,888,084.00	633,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	291,300.00	631,126.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,849,250.00	2,137,500.00
210807	Газрын төлбөр	868,034.00	993,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,057,432,147.15	1,353,234,015.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,932,098,027.15	1,249,172,413.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	125,334,120.00	104,061,602.00
212	ТАТААС	497,038,200.00	0.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	0.00
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	497,038,200.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,843,830,948.70	86,696,834,137.25
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	83,631,731,201.49	85,922,814,797.28
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	83,460,117,410.49	85,732,364,401.28
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	171,613,791.00	190,450,396.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,474,800.00	126,514,421.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	120,014,421.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,474,800.00	6,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	206,624,947.21	647,504,918.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,282,359.55	479,719,931.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	198,342,587.66	167,784,987.82
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,797,900.00	28,169,702.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,797,000.00	28,170,602.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,797,000.00	28,170,602.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,797,000.00	28,170,602.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,797,000.00	28,170,602.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,797,000.00	-28,170,602.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	900.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	900.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөг)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,096,140.00	447,069,397.96	7,369,066,882.30	7,850,232,420.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,946,300.00	-1,946,300.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,096,140.00	447,069,397.96	7,367,120,582.30	7,848,286,120.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-358,983,240.20	-358,983,240.20
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,096,140.00	447,069,397.96	7,008,137,342.10	7,489,302,880.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-128,652,498.00	-128,652,498.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,096,140.00	447,069,397.96	6,879,484,844.10	7,360,650,382.06
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	735,411,200.00	0.00	0.00	735,411,200.00
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	187,307,485.06	187,307,485.06
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	769,507,340.00	447,069,397.96	7,066,792,329.16	8,283,369,067.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	103,158,926,300.00	90,762,458,637.30	12,396,467,662.70	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	103,158,926,300.00	90,762,458,637.30	12,396,467,662.70	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,369,487,500.00	4,713,129,419.02	656,358,080.98	87.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,115,023,100.00	2,748,922,563.23	366,100,536.77	88.2
210101	Үндсэн цалин	2,098,898,500.00	1,947,560,576.31	151,337,923.69	92.8
210102	Нэмэгдэл	823,701,600.00	619,022,602.44	204,678,997.56	75.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	192,423,000.00	182,339,384.48	10,083,615.52	94.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	420,528,100.00	349,927,050.88	70,601,049.12	83.2
210201	Тэтгэврийн даатгал	295,927,200.00	238,521,074.66	57,406,125.34	80.6
210202	Тэтгэмжийн даатгал	31,150,300.00	27,851,744.10	3,298,555.90	89.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,920,100.00	22,281,555.21	2,638,544.79	89.4
210204	Ажилгүйдлийн даатгал	6,230,100.00	5,570,188.71	659,911.29	89.4
210205	Эрүүл мэндийн даатгал	62,300,400.00	55,702,488.20	6,597,911.80	89.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,794,400.00	185,794,400.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	85,200,000.00	85,200,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	74,794,400.00	74,794,400.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	25,800,000.00	25,800,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	115,524,300.00	115,008,781.95	515,518.05	99.6
210401	Бичиг хэрэг	25,606,000.00	25,002,550.00	603,450.00	97.6
210402	Тээвэр, шатахуун	15,963,300.00	15,963,300.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,971,500.00	40,718,866.95	747,366.95	101.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,983,500.00	33,324,065.00	659,435.00	98.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,100,000.00	22,962,300.00	137,700.00	99.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,907,900.00	92,100.00	99.5
210604	Урсгал засвар	3,100,000.00	3,054,400.00	45,600.00	98.5
2107	Томилолт, зочны зардал	14,982,800.00	13,978,985.00	1,003,815.00	93.3
210702	Дотоод албан томилолт	14,982,800.00	13,978,985.00	1,003,815.00	93.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,494,534,800.00	1,276,535,337.96	217,999,462.04	85.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,482,687,600.00	1,272,085,161.96	210,602,438.04	85.8
210803	Даатгалын үйлчилгээ	5,680,500.00	633,150.00	5,047,350.00	11.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	640,900.00	631,126.00	9,774.00	98.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,500.00	55,000.00	99,500.00	35.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,377,900.00	2,137,500.00	2,240,400.00	48.8

210807	Газрын төлбөр	993,400.00	993,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,789,438,800.00	86,049,329,218.28	11,740,109,581.72	88.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	97,654,046,400.00	85,922,814,797.28	11,731,231,602.72	88.0
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	97,463,595,800.00	85,732,364,401.28	11,731,231,398.72	88.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	190,450,600.00	190,450,396.00	204.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,392,400.00	126,514,421.00	8,877,979.00	93.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	128,890,900.00	120,014,421.00	8,876,479.00	93.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,501,500.00	6,500,000.00	1,500.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	103,158,926,300.00	90,762,457,737.30	12,396,468,562.70	0.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	103,158,926,300.00	90,762,303,737.30	12,396,622,562.70	0.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	103,158,926,300.00	90,762,303,737.30	12,396,622,562.70	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	154,000.00	154,000.00	0.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	154,000.00	154,000.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	900.00	900.00	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	239.00	239.00	0.00	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	0.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	0.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	119.00	119.00	0.00	0.0
620001	Удирдах ажилтан	23.00	23.00	0.00	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	92.00	92.00	0.00	0.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	0.00	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан.

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,834,783,232.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,834,783,232.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,666,998,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	89,175,000.00
210401	Бичиг хэрэг	73,001,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,999,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,175,000.00
2105	Нормативт зардал	55,160,700.00
210502	Хоол, хүнс	55,160,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	122,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000,000.00
210602	Тавилга	7,600,000.00
210604	Урсгал засвар	14,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	41,543,800.00
210702	Дотоод албан томилолт	41,543,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,358,718,745.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,254,657,143.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,061,602.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167,784,987.82
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	167,784,987.82
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,834,783,232.82
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,834,783,232.82
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж.	1,750,429,232.82
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө.	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө.	74,354,000.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хөрөнгө, материалыг зөв дансанд ангилж бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитор С.Бат-Эрдэнэ, Г.Түвшинзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 3/183 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох, нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх;
- Хүн ам, түүний бүлгүүдийн хөгжлийг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, стратеги, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн харилцааны талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;
- Хүн амын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн нийгмийн хамгааллын хууль тогтоомж, бодлого, стратеги, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах;

- Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоодын хяналт шалгалт, аудит хийх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд тус яамны санхүүгийн 2019 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, иргэн аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээний үр дүнг дүгнээгүй, үнийн дүн гүйцэтгэсэн ажлын утга зөрүүтэй, тайлан анхан шатны баримтын бүрдэл баримтаар санхүүжилтийг бүрэн шилжүүлсэн зэрэг 32,500.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, арга хэмжээ авч ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 94,160,001.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 941,600.0 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажуулав.

Гүйцэтгэлийн үе шатанд 941,593.2 мянган төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тогтоосон нь залруулга хийгдсэн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтийн дүнгээс тооцсонтой холбоотой.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 787,341.7 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, нөөцийн бараа, үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.9	0	(0.9)
Авлага	218,072.0	174,311.1	(43,760.9)
Урьдчилгаа	160,647.1	88,627.6	(72,019.5)
Бараа материал	104,636.4	211,957.5	107,321.1
Бусад эргэлтийн хөрөнгө	220,000.0	537,179.3	317,179.3
Үндсэн хөрөнгө	6,796,692.4	7,275,314.9	478,622.5
Нийт хөрөнгө	7,500,048.8	8,287,390.5	787,341.7
Өр төлбөр	10,745.9	4,021.4	(6,724.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,489,302.9	8,283,369.1	794,066.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,500,048.8	8,287,390.5	787,341.7

Мөнгөн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 0.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж жилийн эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 174,311.1 мянган төгрөг болж өмнөх оноос 43,760.9 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэгдсэн авлагын хэмжээ өмнөх оноос буурсан нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 211,957.5 мянган төгрөг болж өмнөх оноос 107,321.1 мянган төгрөгөөр өссөн нь Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка) болон Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл хэрэгжиж дууссантай холбоотойгоор ашиглагдаж байсан бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд тараах зориулалттай ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис зэрэг материал үлдэгдлээр бүртгэлтэй байгаагаас шалтгаалсан байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 537,179.3 мянган төгрөг болж өмнөх оноос 317,179.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төслийн хөрөнгөөр 11 дүгээр сард бэлтгэсэн 537,179.3 мянган төгрөгийн зөөврийн болон суурин компьютер, таблет, бусад дагалдах хэрэгслүүдийг короно вируст халдварын (Ковид-19) үеийн хөл хорионы улмаас харьяа газруудад хуваарилагдаагүй үлдэгдлээр бүртгэлтэй байна.

Эхний үлдэгдэлд бүртгэлтэй 220,000.0 мянган төгрөгийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын мэдээллийн нэгдсэн системийн программыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,275,314.9 мянган төгрөг болж 478,622.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 59,915.0 мянга, урсгал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28,170.6 мянга, ХХҮЕГ-аас шилжүүлсэн авсан 76,835.0 мянга, Японы хамтын ажиллагааны байгууллага (Жайка) болон Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл болон бусад эх үүсвэрээс шилжүүлэн авсан 762,856.1 мянга, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолборын эзэмших эрхтэй газрыг үнэлж бусад биет бус хөрөнгийн дансанд бүртгэсэн 735,411.2 мянган төгрөг зэрэг нийт 1,663,187.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А-1/1250 тогтоолын

дагуу 33,563.2 мянган төгрөгийн программ хангамжийг акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,021.4 мянган төгрөг болж 6,724.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос шилжин ирсэн 10,745.9 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан боловч төсвийг зохистой удирдаагүйгээс 4,021.4 мянган төгрөгийн бичиг хэргийн зардалтай өглөг үүсгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,282,369.1 мянган төгрөг болж 794,066.2 мянган төгрөгөөр өссөн нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай тоноглол бүхий спорт цогцолборын эзэмших эрхтэй газрыг үнэлж 735,411.2 мянган төгрөгөөр засгийн газрын оролцоо дансанд бүртгэсэн, 128,652.5 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга бичилт хийсэн, тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан үр данс 187,307.5 мянган төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,517,706.8 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал төсвийн санхүүжилт 2,416,193.8 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалын 1,236,885.7 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь ХНХЯ-ны дэргэдэх Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын (Жайка) болон Азийн хөгжлийн банкны Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилтийн төсөл хэрэгжиж дууссантай холбоотойгоор тус төсөлд ашиглагдаж байсан хөрөнгийг шилжүүлэн авсан нь голлон нөлөөлж байна.

Нийт зардал өмнөх оноос 1,750,993.9 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, засгийн газрын дотоод шилжүүлгийн зардал нэмэгдсэн, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, томилолт, зочны зардал буурсан байна. Энэ нь тайлант жил төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн болон Ковид 19 цар тахалтай холбоотойгоор хөдөө орон нутагт ажиллаагүй зэргээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 128,652.5 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх оны татаас санхүүжилтийн авлагын үлдэгдлийг төсөл хөтөлбөрүүдэд буцаасан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 133,241,319.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 133,241,319.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29,255,304.3 мянган төгрөгөөр бууруулж 103,986,015.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь засгийн газрын дотоод шилжүүлгийн зардлыг 20,184,909.6 мянган төгрөгөөр, төрийн өмчит байгууллагад олгох татаасыг 1,715,654.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 8,202,526.2 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн хураамжийн зардлын урьд онд үүссэн өр төлбөрийн үлдэгдлийг нэмж тусгасныг Сангийн яам бууруулж хянасан, мөн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн

харилцааны хөтөлбөрийн, ахмад настны хөгжил хамгааллын зэрэг арга хэмжээний зардлыг өндрөөр төлөвлөснийг хасаж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны тодотгосон төсвөөр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 103,158,926.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 91,242,023.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 90,762,303.7 мянган төгрөгийг зарцуулж 479,565.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 90,762,458.6 мянган төгрөг буюу 88 хувьтай байгаа нь урсгал шилжүүлгийн зардал 11,731,231.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 656,358.1 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь нийгмийн даатгал хөтөлбөрийн эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл арга хэмжээ 11,645,543.7 мянган төгрөгөөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагаа, улс орноо гадаад сурталчлах, цэргийн алба хааж байсан иргэдийн НДШ, мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээ нийт 676,233.6 мянган төгрөгөөр, Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, удирдлага хөтөлбөрийн 82614 хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны арга хэмжээ 39,688.5 мянган төгрөгөөр, Хүүхдийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн хүүхэд хамгаалал арга хэмжээ 28,500.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Тухайлбал: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан, тэтгэмж авах эрх үүссэн эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг эх өөрөө төлнө гэж заасны дагуу олгож байгаа тэтгэмжийг сүүлийн 2 жилийн төрөлтийн судалгаан дээр үндэслэн 2020 оноос анх удаа төсөвт суулгасан боловч гүйцэтгэлээр 14.5 хувь нь зарцуулагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сан, Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Германы хамтын ажиллагааны байгууллага, Швейцарийн хөгжлийн агентлаг, Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг гадаад төсөл хөтөлбөрүүдээс 1,750,429.2 мянга, Засгийн газрын нөөц сангаас 10,000.0 мянга, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 74,354.0 мянга, нийт 1,834,783.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 89,175.0 мянга, нормативт зардалд 55,160.7 мянга, эд хогшил урсгал засварын зардалд 122,400.0 мянга, томилолт, зочны зардалд 41,543.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 1,358,718.7 мянга, нийт 1,666,998.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 167,785.0 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлж 20.0 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэн, Сангийн яамтай тооцоо нийлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих 144 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 9 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Тухайлбал:

- Тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 15 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 140,231.8 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг тус тус мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 162,401.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 81,137.7 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснөөс албан шаардлага бүрэн хэрэгжиж, 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй байх талаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/мянган.төг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	162,401.5	2	162,401.5	-	-	100
Зөвлөмж	7	81,137.7	6	71,237.7	1	9,900.0	87.8
Нийт	9	243,539.2	9	233,639.2	1	9,900.0	93.9

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 356,132.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 17,690.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 282,629.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 55,813.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн арга хэмжээний зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд ангилал буруу бүртгэсэн 17,690.6 мянган төгрөгийн алдааг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй зөрчлөөс 282,629.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1.Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 73,741.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж, үр дүнг мэдээллээгүй байна. Үүнд:

- Шатахууны худалдан авалтын 12,841.5 мянга;
- Интернет, шуудан үйлчилгээний 22,900.0 мянга;
- Бичиг хэргийн материалын 20,000.0 мянга;
- Салбарын тэргүүний ажилтны тэмдэг хийлгэх 18,000.0 мянган төгрөгийн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 -т "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 21 дүгээр зүйлийн 21.4-т "Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1, 12-т заасан цахим хуудсан байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ", Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4.3-т "худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх" заасантай тус тус нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж худалдан авах ажиллагааны журмыг сонгох байтал харьцуулалтын аргын журмаас зайлсхийж ухаалаг самбар нийлүүлэх ажлын 19,688.9 мянган төгрөгийн төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 8.7.1-д "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3.Тус яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй орон тоонд хэвлэлийн ажилтан, гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан, бичээч зэрэг нийт 7 хүнийг гэрээгээр ажиллуулж 48,966.8 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заасантай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Шилэн дансны цахим хуудсанд төсвийн гүйцэтгэлийн 1,2,3,5,6,7,9 дүгээр сарын мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 140,231.8 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг мэдээлээгүй нь зэрэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, 6.1.6, 6.4.4-т заасантай нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 55,813.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитаар анхаарал татахуйц дараах асуудлууд байна. Үүнд:

- Тус байгууллагын санхүүгийн тайланд ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 201 нэр төрлийн 798,878.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байхад эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх санал, хүсэлтийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтыг газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.
- Тус яам нь тайланд онд ХХҮЕГ-аас 76,835.0 мянган төгрөгийн Nissan teana, Хүнс тэжээл нийгмийн халамж төслөөс Hyundai starex маркийн 69,318.7 мянган төгрөгийн, Соната LF маркийн 61,694.6 мянган төгрөгийн дансны үнэтэй 3 автомашиныг шилжүүлэн авснаар жилийн эцсийн байдлаар 467,146.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий 8 тээврийн хэрэгслийг эзэмшиж байна.
- Засгийн газраас тогтоосон бүтэц орон тооны дээд хязгаарт багтаагүйн улмаас тооны нягтлан бодогч, нярав, жолооч, гараажийн харуул, үйлчлэгч зэрэг төрийн үйлчилгээний 11 ажилтныг байр ашиглалтын үйлчилгээний зардлаас цалинжуулж байна. 2020, 2021 оны төсвийн саналд орон тоог нэмэгдүүлэх төлөвлөж ирсэн боловч Сангийн яамнаас нэмж батлаагүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Дотоод аудиттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 20,692.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосныг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг аваагүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж арга хэмжээ авч ажиллана.

2.Балансын данстай холбоотой асуудал /бараа материал/

2.1. Илрүүлэлт:

Иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан Хүүхэд, өсвөр үеийнхнийг цахим орчны зохистой хэрэглээнд сургах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим болон хэвлэмэл контент хийлгэх гэрээний урьдчилгаа төлбөрт 17,700.0 мянган төгрөгийг, журам шинэчлэн боловсруулах гэрээний урьдчилгаа төлбөрт 2,800.0 мянган төгрөгийг олгосон боловч гэрээний үүргийг хугацаанд нь хангуулаагүй, гэрээг дүгнээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", гэрээний холбогдох заалттай нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Төлөвлөсөн хөтөлбөр, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулж, ажил үйлчилгээг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан хүлээн авах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ковид 19 цар тахлын үеийн удаа, дараалсан хөл хорионы улмаас гүйцэтгэл хойшлогдсон ба 2021 оны 01-р улиралд багтаан гэрээний үүргийг хангуулж ажиллана.

3.Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаж дансны өр төлбөрийн тооцоог хянаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 6,546.0 мянган төгрөгийн авлага, 4,021.4 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах.

3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, он дамжсан авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 2021 оны 1 дүгээр улиралд багтаан дээрх авлага, өр төлбөрийг барагдуулах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.Балансын данстай холбоотой асуудал /бараа материал/

4.1. Илрүүлэлт:

Хуульд заасан хугацаанд хүүхдээ асрах 3 жилийн чөлөөтэй ажилтныг ажилд нь томилоогүйгээс ажилтны жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгалын сангаас санхүүжүүлэх эрх үүсээгүй тул байгууллагын төсвөөс 2,248.1 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2-т “ Хүүхэд асрах чөлөө дууссан, эсхүл дуусаагүй боловч эх эцэг өөрөө хүсвэл ажил олгогч түүнийг ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах үүрэгтэй бөгөөд хэрэв орон тоо нь хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн бол түүнд өөр ажил олж өгнө”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “ Энэ хуулийн 19.1 дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн эхэд тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 100 хувиар тооцож 4 сарын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно”, 24 дүгээр зүйлийн 24.2-т “ Ажил олгогч өөрөөсөө шаардагдах баримт бичгийг саадгүй бүрдүүлж өгөх үүрэгтэй” гэж заасантай нийцэхгүй үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс хөдөлмөрийн маргаан үүсэх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөж ажиллах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5.Балансын данстай холбоотой асуудал /бараа материал/

5.1. Илрүүлэлт:

Аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 1,805.5 мянган төгрөгийн проекторын дэлгэцийг бараа материалын дансанд бүртгэсэн нь УСНББОУС-17-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө;б) нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм", заасантай нийцээгүй, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд хөрөнгийн ангилал зөрүүтэй илэрхийлэгдэж, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байх.

5.3. Өгсөн зөвлөмж:

Бусад хангамжийн материалын дансанд бүргэгдсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж бүртгэх.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, 2021 оны хоёрдугаар улиралд багтаан залруулна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит.	Аудитын код:
2020			САГ-2020/355/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулж, үр дүнг мэдээлээгүй.	73,741.5	Албан шаардлага өгөх	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
2	Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж худалдан авах ажиллагааны журмыг сонгох байтал харьцуулалтын аргын журмаас зайлс хийж ухаалаг самбар нийлүүлэх ажлын төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн.	19,688.9	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
3	Тус яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй орон тоонд хэвлэлийн ажилтан, гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан, бичээч зэрэг нийт 7 хүнийг гэрээгээр ажиллуулж цалин, НДШ-ийн зардал гаргасан.	48,966.8	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
4	Шилэн дансны цахим хуудсанд төсвийн гүйцэтгэлийн 1,2,3,5,6,7,9-р сарын мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягыг мэдээлээгүй.	140,231.8	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа

5	Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон 1 ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны цалинг төсвөөс нөхөн олгосныг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг аваагүй байна.	20,692.0	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
6	Иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан Хүүхэд, өсвөр үеийнхнийг цахим орчны зохистой хэрэглээнд сургах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх цахим болон хэвлэмэл контент хийлгэх гэрээний урьдчилгаа төлбөрт 17,700.0 мянган төгрөгийг, журам шинэчлэн боловсруулах гэрээний урьдчилгаа төлбөрт 2,800.0 мянган төгрөгийг олгосон боловч гэрээний үүргийг хугацаанд нь хангуулж, гэрээг дүгнээгүй.	20,500.0	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
7	Төсвийг зохистой удирдаж дансны өр төлбөрийн тооцоог хянаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 6,546.0 мянган төгрөгийн авлагын, 4,021.4 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй тайлагнасан.	10,567.4	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
8	Хуульд заасан хугацаанд хүүхдээ асрах 3 жилийн чөлөөтэй ажилтныг ажилд нь томилоогүйгээс ажилтны жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгалын сангаас санхүүжүүлэх эрх үүсээгүй тул тэтгэмжийг байгууллагын төсвөөс олгосон.	2,248.1	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
9	Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.	1,805.5	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Төрийн нарийн бичгийн дарга, нягтлан бодогч	Г.Өнөрбаяр, Л.Сансартуяа
ДҮН		338,442.0			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 87/АМТ0065

Улаанбаатар хот

САТ-2021/355/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарт батлагдаагүй хэвлэлийн ажилтан, гадаад хамтын ажиллагаа хариуцсан ажилтан, бичээч зэрэг орон тоонд нийт 7 хүнийг гэрээгээр ажиллуулж цалин, НДШ-ийн 48,966,787 (Дөчин найман сая есөн зуун наян долоо мянга долоон зуун жаран долоо) төгрөгийн зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бүтэц орон тооны хязгаарт батлагдаагүй орон тоонд гэрээт ажилтан томилон ажиллуулсан зөрчлийг бүрэн арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нягтлан бодогч П.Сансартуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ

Г ТҮВШИНЗАЯА
С БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 88/АОТ/0065

Улаанбаатар хот

САГ-2021/355/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээллийг 1,2,3,5,6,7,9-р сард, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай зэрэг мэдээллүүдийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 16 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 140,231,848 (Нэг зуун дөчин сая хоёр зуун гучин нэгэн мянга найман зуун дөчин найм) төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд хуульд заасан хугацаанд мэдээлээгүй болон мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нягтлан бодогч Л.Сансартуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Г.ТҮВШИНЗАЯА
С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 89 / АМТССББ

Улаанбаатар хот

САГ-2021/355/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хуульд заасны дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж худалдан авах ажиллагааны журмыг сонгох байтал харьцуулалтын аргын журмаас зайлсхийж 19,688,900 (Арван есөн сая зургаан зуун наян найман мянга есөн зуун) төгрөгийн ухаалаг самбар нийлүүлэх ажлын төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.


Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", 8.7.1-т "тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдах этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгож төсөвт өртгийг хуваасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нягтлан бодогч Л.Сансартуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ТҮВШИНЗАЯА
С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 90/АДИТООББ

Улаанбаатар хот

САГ-2021/355/СТА-ТУЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зохион байгуулсан 73,741,500 (Далан гурван сая долоон зуун дөчин нэгэн мянга таван зуун) төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээний тендерийг худалдан авах ажиллагааны цахим системээр зохион байгуулаагүй байна. Үүнд:

- Шатахууны худалдан авалтын 12,841,500 төгрөгийн;
- Интернет, шуудан үйлчилгээний 22,900,000 төгрөгийн;
- Бичиг хэргийн материалын 20,000,000 төгрөгийн;
- Салбарын тэргүүний ажилтны тэмдэг хийлгэх 18,000,000 төгрөгийн;

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 -т "Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана", 21 дүгээр зүйлийн 21.4-т "Захиалагч урилгыг энэ хуулийн 52.1, 12-т заасан цахим хуудсан байрлуулж, тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ", Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.4.3-т "худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох олон нийтээр урьдчилан хэлэлцүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх" заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг цахим системээр зохион явуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Нягтлан бодогч Л.Сансартуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ТҮВШИНЗАЯА
С.БАТ-ЭРДЭНЭ

